

Буддын гүн ухааны үзэл онолоос

Доктор Т.Булган

“Миний номын ёсноо хоёр зүйл буюу

Үзүүлэхүй /сургаал/ болоод тогтсон таалал болой

Нялхас нарт сургаалаа номнов

Бүтээлчин нарт тогтсон тааллаа айлдав”

(“Ланка тивд ажарсан судар”-аас)

Буддын гүн ухааны ёсноо “Дотоодын буюу өөрийн ёсныхон” ба “Гадаадын буюу буддын бус ёсныхон гэж хоёр ангилж тэдгээрийн ертөнцийг үзэх үзэл онол, философи сэтгэлгээ, гүн ухаан зэргийг нарийвчлан авч үздэг. Ийнхүү гүн ухааны зөв ойлголт, үнэн чиг баримтлал, үзэл онолыг сайтар судлах болон тэр талаар үнэ зөв ойлголт, ухаарал, мэдлэг ухааныг эзэмших нь буруу үзлийн хүлээснээс ангижирч, зовлонгийн үндсийг таслах, оюун сэтгэхүйн гэгээрэлд хүрэх гол аргын нэгэн болно гэж буддын гүн ухаанд үздэг. Энэ талаар:

“Ахуй ёсыг оносон билиг үл төгсвөөс

Магад гархуй ба бодь сэтгэлд дадан үлйдэвч

Сансрын үндсийг үл чадах

Тиймийн тул шүтэн барилдлагыг онохын аргад хэчээгтүн” хэмээсэн буй.

Энэ зорилгын үүднээс, Буддха өөрийн номын ёсноо” Сургаал ба тогтсон таалал” гэсэн хоёр номын ай сав байгааг тодорхойлсон байна. Энд өгүүлж буй “**Тогтсон таалал**” гэдэг чухамдаа буддын гүн ухааны ёсны үүднээс дотоод, гадаад гүн ухааны үзэл онолын нарийн ялгаа, өөрийн ёсны үзэл баримтлал зэргүүдээ тодорхой үзүүлсэн ертөнцийг үзэх үзэл онолын цогц тогтолцоо бүрэлдэж ирснийг илэрхийлжээ.

Ер нь “Дотоодын”/ Буддын номт/ гэдэг бол “Чин сэтгэлээс чухаг дээд гуравт аврал итгэл одуулж, тэднийг авралаа итгэлд баригч нар” болно. Энэ талаар “**Тогтсон тааллын ялгал-Эрдэнийн эрхи**”-ээс: “Үнэн зүрхнээс гурван эрдэнэд итгэл явуулсан тэр дотоод хийгээд” хэмээсэн буй.

Харин “гадаадынхан”/Буддын номт бус, тэртигүүд/ бол “чухаг дээд гуравт итгэхгүй, авралд барихгүйгээр ертөнцийн тэнгэр зэрэгт чин сэтгэлээс авралд баригч нар” ажээ. Тэр тухай “Тогтсон тааллын номлол-Эрдэнийн эрхи”-д: “Гурван эрдэнэд оюуныг хатангатал үгүй еэ ертөнцийн тэнгэрт үнэн зүрхнээс итгэл явуулсан бодьгаль тэр гадаад мөний тул” хэмээжээ.

Ялангуяа “тогтсон таалал буюу ертөнцийг үзэх үзэл онол”-ын хувьд ч “дотоодын тогтсон тааллын аймагтан” ба “гадаадын тогсон тааллын аймагтан” гэж үзэхдээ. “*Багш нь ямар болох, түүний үзүүлсэн ном/шашин/ ямар болох,*

үзэл онол ямар байх” гэсэн гурван зүйлийн үүднээс ялгаж үзнэ. Энэ талаар “Дунта зава”/Тогтсон тааллын үндэс/-наас айлдахдаа: “Үзүүлсэн ном, багш, үзэл онолын үүднээс гадаад, дотоод гэж хоёр үзнэ” хэмээжээ.

Тухайлбал “Дотоодын аймгийн “багш” болвоос хамаг гэм буруугаа барсан, эрдэм бүхнийг төгсгөсөн ба, “заасан ном” нь амьтан хүнд ямарваа хорлол болохгүй ба, “үзэл онол “нь “мөнх, гагцаар, өөрийн эрхтэй байх – “би” гээс хоосон” байх зэрэг гурван зүйлээр бусад тогтсон таалалтны аймгуудаас ялгагдана.

Мөн буддын гүн ухааны аймгийнхан “Дөрвөн мутар” хэмээх дөрвөн гол зарчимаар бусад ертөнцийг үзэх үзлүүдээс ялгагдана. Энэ талаар дээрх эшүүдээс: “Зарлигт хадсан дөрвөн мутрыг аман авагч бодьгаль тэр дотоод бурхантны тогтсон таалал өгүүлэгчийн бэлэг чанарт агуулмой. Дөрвөн/тамга/ мутар буй. Үүнд:

Хамаг хуран үүдсэн мөнх бус

Хамаг цувиралт зовлонт

Хамаг номууд би үгүй

Гаслангаас нөгчигсэн амарлингуй болой.” хэмээсэн буй

Үүгээр мөн дотоодын тогтсон тааллын аймгийн мөн чанар тодорхойлогдоно. Буддын гүн ухааны тогтсон тааллын аймаг буюу философийн аймгууд чухам хэдийд гарсан талаар үзэхдээ, Шагжа хаан буюу Буддха багш бээр анхлан бодь сэтгэлийг олж, улмаар цаглашгүй гурван их галбын буяны чуулганыг хурааж, эцэст нь илт туулсан бодь хутагийг олж Энэ Замбутивийн Хутагтын орон хэмээх Энэтхэгийн “Очирт суудал” хэмээх дагшин газарт гэгээрсэн аж. Чингээд хамаг амьтны тусыг бүтээхээр “амьны тус амгалан гарахын гагц үүд болсон “Номын хүрд”-ээ амьтан тус тусын санааа бодолд тааруулан хөтлөхөөр гурвантаа эргүүлжээ. Анхны номын хүрд буюу “Хутагтын дөрвөн үнэн”-ий зарлигаа Варанасын ой цэцэрлэг хэмээх газар бага хөлгөнийхэнд зориулж Ади санбу тэргүүтэн таван шавьдаа номносон ба, дэд номын хүрдэн буюу “Мөн чанар үгүй буюу хоосон чанар” заасан зарлигаа их хөлгөний шавь нарт зориулан “Тасын цогцост уул”-наа/Ражгир/, Гутгаар номын хүрд буюу “Сайтар ялгасан номын хүрдээ Янбажан хэмээх газар их бага хөлгөний олон шавь нартаа тус тус эргүүлжээ.

Чухамхүү Буддха багшийн айдсан тэрхүү “Номын гурван хүрд “- ний номыг даган суралцах , судлах болон таалал утгыг тайлбарлах ухаарах зэрэг номын их үйл хэргээс улбаалан буудын ертөнцийг үзэх үзэл онолын аймгууд үүдэж гарсан түүхтэй аж.

Энэ талаар “Тогтсон тааллын тайлбар”-аас өгүүлэхдээ: “Анхан нь сац үгүй Бурхан багш Сахьяалигийн хаан тэрбээр, эхлээд бодь сэтгэл үүсгээд, дунд нь гурван асанхи галбад чуулганын хурааж, эцэст Очирт суурины оргилд Илт туулсан бурхан болж, Варанасын орноо таван аймагийн сайн нөхдөд дөрвөн үнэний номын хүрдийг эргүүлэв. Тасын цогцост уулнаа их хөлгөний шавь нарт “өвсбээн чанар үгүйг/хоосон чанар/ үзүүлсэн номын хүрдийг эргүүлэв. Тэндээс Вайшали тэргүүтэнд сайтар тийн бөгөөд нээгч номын хүрдэн агуу ихэд

эргүүлж, тиртэг нарын зургаан багш тэргүүтний муу өгүүлэгч бүгдийг сүрээр дарж, тус амгалан гархын орон бурханы шашин эрдэнийг өргөжин дэлгэрүүлэн зохиожээ.

Түүний сүүлээр тайлбар зохиогчид бээр “Гурван хүрд”-ний таалал тус тусад тайлбарласанд шүтэж дөрвөн тогтсон таалал өгүүлэгчид гарсан бөгөөд тэдгээрээс гадаад утга өгүүлэгч хоёр аймаг нь анхны хүрдэнг, мөн чанар үгүйеэ өгүүлэгч бээр дунд хүрдэнг ба, йогын явдалтнууд бээр эцсийн хүрдний хойноос дагаж, шүтээн, мөр, үр гурвын тийн агуулгыг тангараглан үйлдэх “ хэмээн тодорхойлсон байна.

Тэдгээр Дотоод тогтсон тааллын аймгийг ялгаваас: 1. Өвөрмөц өгүүлэгч /Вайбхашика/, 2. Судрын аймагтан /Сутрантика/, 3. Сэтгэлийн төдийтэн /Ёгочара/, 4. Мөн чанарыг үгүйсгэн өгүүлэгч /Мадхьямика/ гэсэн дөрвөн аймаг болой.

Мөн эдгээр аймгууд нь үзэл онолын хувьд мөнх болон тасархайн хязгаар туйлшралаас ангижирсан “төв үзэлтнүүд” гэж үзэх хэдий ч Хэтрүүлэгч төв үзэлтэнтэй харьцуулбал, доод аймгууд нь харьцангуй тэр хоёр хязгаараас ангижирч чадаагүй гэж үзнэ. Үүний учрыг дөрвөн аймгуудын мөнх тасархайн хязгаараас ангижрах тухай харилцан адилгүй болгоолоос мэдэж болно.

Өвөрмөц өгүүлэгч нар үзэхдээ “Үр төрөхийн цагт шалтгаан түрдэх /хаагдах/ учир мөнхийн хязгаар тэвчигдэх” ба “Шалтгааны сүүлд үр гарах тул тасархайн хязгаарыг тэвчмүй” хэмээнэ. Судартангууд үзэхдээ “Хуран үүдсэн бүхэн үргэлжлэн тасралтгүй үүдэх тул тасархайн хязгаараас ангижрах, мөн агшин бүрт эвдрэх учир мөнхийн хязгаараас гэтлэх” гэнэ. Сэтгэлийн төдийтнүүд үзэхдээ “Бүхэн нэрийдсэн үнэн эс бүтсэн тул мөнхийн хязгаарыг тэвчих ба бусдын эрхэт үнэхээр бүтсэн тул тасархайн хязгаарыг тэвчсэн” гэнэ.

Төв үзэлтэнгүүд “Хамаг ном юмс нэрийтгэлд буйн тул тасархайн хязгаараас гэтлэх бөгөөд үнэмлэхүйд байхгүй тул мөнхийн хязгаараас гэтэлмүй “ хэмээн үздэг байна. Хэдий эл дөрвөн таалал харилцан адилгүй, дээдхи нь доодхи тааллаа үгүйсгэх хэдий ч дээд ухаанд хүрэхийн ухаарахын тулд доодхи шатаа мэдэх учиртай тул онож мэдэхийн шүтэн барилдлагатай ажээ.